

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн, Сүхтэй Эрдэнэсайхан

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
1.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, стандартын хэрэгжилтийг хангах, орчны эрүүл ахуй, аюулгүй байдал, хоол шим тэжээлийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн хоолны аюулгүй байдал, эрүүл ахуйд хяналт тавих, хүний нөөцийг чадавхжуулах, сургалт зохион байгуулах.							
1	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг үдийн сүүгээр хангах “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх /ҮАХ-2.2.2.13/	- Хөтөлбөрт хамрагдсан сурагчдын тоо - Гүйцэтгэлийн хувь	78,400	80,000	“Сүү хөтөлбөр”-ийн хүрээнд Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Орхон, Төв, Хэнтий, Дархан-Уул зэрэг 12 аймаг болон нийслэл, нийт 97 цэцэрлэг, 144 ерөнхий боловсролын сургуулийн нийт 85,262 суралцагч эцэг эх, орон нутгийн дэмжлэгтэйгээр тус хөтөлбөрт хамрагдаад байна. Хөтөлбөрийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 3.1 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна. Боловсролын ерөнхий газрын 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 1/662 дугаар албан бичгийн дагуу сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл”-ийг аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Тус зөвлөмжийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хоёрдугаар хэсэгт сүү, сүүн бүтээгдэхүүнийг 7 хоногт 2-оос доошгүй удаа хоолны цэсэд төлөвлөх чиглэл өгсөн. Боловсролыг ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/73, 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/135 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар 14, 158, 52, 31, 124, 28, 145, 55, 116, 29, 63, 302, 1, 160, 38,10, 186 дугаар цэцэрлэг, нийт 17 цэцэрлэг, ЕБ-ын сургуулийн хоолны цэсэд хяналт хийхэд 7 хоногт 2-3 удаа сүү, сүүн бүтээгдэхүүнийг оролцуулсан хоолны цэс төлөвлөн хэррэгжүүлж байна. Хавсралт: 9 файл		
2	Засгийн газрын 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хоол үйлдвэрлэл, үйлчилгээний түрээсийн гэрээг үе шаттайгаар дуусгавар болгох	- Хамрагдах байгууллагын тоо - Гүйцэтгэлийн хувь	2024-2025 оны хичээлийн жилд аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын 75 сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээг түрээсийн гэрээгээр явуулж байна.	15	1. Хууль тогтоомжийг биелэлтийг хангуулах хүрээнд БЕГ-ын даргын 2025.02.13-ны өдрийн 1/662 дугаар тоот албан бичгээр Сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх хүрээнд "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл"-ийг аймаг нийслэлийн Боловсролыг газарт хүргүүлсэн. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 75 сургууль түрээсийн гэрээгээр гүйцэтгэж байсан. БЕГ-ын чиглэлийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 17 сургууль түрээсийн гэрээг дуусгавар болгож ХҮҮ-г бие даан хэрэгжүүлж эхэлсэн. 2025 оны 05 дугаар сарын байдлаар нийт 58 сургууль ХҮҮ-г түрээсийн гэрээгээр хэрэгжүүлж байна. 2. Түрээсийн гэрээг дуусгавар болгох ажлын хүрээнд Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/135 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан нийслэлийн ерөнхий боловсролын 133, 102, 33, 44, 97, 84, 12, 104, 105, 162, 55, Хөгжил болон Баянзүрх цогцолбор сургуулиудад ажиллан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сургуулийн захирлуудад үүрэг чиглэл өгч ажилласан. Тус 13 сургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан, засвар үйлчилгээ хийгдсэн боловч хүний нөөц олдохгүй гэсэн шалтгаанаар түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байна. Сургуулийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					захирлуудад хууль тогтоомжийн дагуу хүний нөөцийг бүрдүүлж ажиллах чиглэлийг ажлын хэсгээс өгсөн. 3. Боловсролын ерөнхий газрын 2025.02.13-ны өдрийн үүрэг чиглэлийн дагуу Дархан-Уул аймаг түрээсээр ХҮҮ-г хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулиудад 1,5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвөөр шийдвэрлэж бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж түрээсийн гэрээг дуусгавар болгосон. Хавсралт: 8 файл		
3	MNS 7005:2023 стандартын өөрийн үнэлгээний ажлыг зохион байгуулах / эхний хагаст 1 үнэлгээний аргачлал боловсруулж батлуулсан байна , жилийн эцэст нэгж байгууллагуудын 90% хүргүүлсэн байна./	Батлуулсан аргачлалын тоо Өөрийн үнэлгээг зохион байгуулсан сургуулийн тоо	0	1	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/178, А/238, А/173 дугаар хамтарсан тушаалын хавсралт "Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын журам"-д Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өгсөн чиг үүргийн дагуу "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээний аргачлал"-ыг Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/80 дугаар тушаалаар баталсан. Аргачлалыг боловсруулах хүрээнд зөвлөх үйлчилгээгээр 2025 оны 02 дугаар сарын 28 -ны өдөр дахин хэлэлцүүлж сайжруулалт хийж батлуулсан. Батлагдсан аргачлалыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 1/1261 дугаар тоот албан бичгээр 21 аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэн өөрийн үнэлгээг зохион байгуулах чиглэлийг өгсөн. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
4	Дунд ахлах ангийн сурагчдыг үдийн хоолонд хамруулах чиглэлээр зөвлөмж уриалга боловсруулан	Дунд, ахлах ангийн суралцагчдыг үдийн хоол, цайны үйл ажиллагаанд хамрагдсан суралцагчдын	9600	10778	Дунд ахлах ангийн сурагчдыг үдийн хоолонд хамруулах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнд 6-12 дугаар ангийн 17952 суралцагч хоолны үйлчилгээнд хамрагдаж байна. Үүнд: 1. "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл"-ийг аймаг, нийслэлийн Боловсролын газарт 2025.02.13-ны 1/662 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Зөвлөмжийн 2 дугаар хэсэгт дунд, ахлах ангийн сурагчдын хоол шим тэжээлийн байдлыг сайжруулах арга хэмжээг эцэг эх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	100%

	нэгж байгууллагад хүргүүлэн, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	тоо			болон орон нутгийн дэмжлэгтэй зохион байгуулах чиглэлийг өгсөн. Тус чиглэлийн хүрээнд Говь-алтай, Завхан, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Ховд 7 аймгийн 81 сургуулийн 6-12 ангийн 17952 суралцагч үдийн хоолонд хамрагдаж байна. суралцагчдыг хоолны үйлчилгээнд хамруулахад 1,3 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлээд байна. 2. "Fix my food" нөлөөллийн ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд Дорнод аймагт сургуулийн хоол шим тэжээлийн орчныг үнэлэхэд суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх арга зүй дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. тус сургалт үйл ажиллагааг Нийгмийн эрүүл мэндийн төв, Дэлхийн зөн ОУБ, тус аймгийн Боловсрол, Эрүүл мэндийн газар, Монголын хүүхдийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Сургуулийн орчны үнэлгээнд аймгийн төвийн нэг дүгээр сургууль, Хан-Уул сургуулиуд хамрагдсан. Аймгийн хүүхдийн зөвлөлийн 10, 11 дүгээр ангийн 20 суралцагч хамрагдаж 2 сургууль дээр үнэлгээ зохион байгуулсан. 4. Дунд, ахлах ангийн суралцагчдыг үдийн хоолонд хамруулах ажлын хүрээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бэлтгэл хангагдсан эсэх, тоног төхөөрөмжийн судалгааны QR-ыг 2025 оны 05 сарын 05 -ны өдрийн 1/1625 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Тус судалгаанд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 705 сургуулиас 556 сургууль буюу 78,8% нь хамрагдсан байна. Хавсралт: 7 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	
5	Хоёр болон түүнээс дээш хоол үйлдвэрлэлийн байртай сургуулийн гал тогоог нэгтгэх эдийн засгийн тооцоо	-	- Судалгаанд хамрагдсан орон нутгийн тоо, Гал тогоог нэгтгэсэн байгууллагын тоо	22	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.2. дахь хэсэгт "Хоёр болон түүнээс дээш хичээлийн байр, дотуур байртай сургууль нэг гал тогоотой байж болно" гэж тусгагдсаны дагуу Япон Улсын "Жайка" олон улсын байгууллагатай хэрэгжүүлж буй төслийн 2 дахь үе шатанд дундын гал тогоо байгуулах хүсэлтийг хүргүүлсэн. Үүнд: 1. Хоёр болон түүнээс дээш хичээлийн байр, дотуур байртай сургуулийн судалгааг Боловсролын ерөнхий газрын 2025 оны 04 дүгээр сарын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	100%

	судалгаа хийнэ.				22-ны өдрийн 1/1455 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Тус судалгаагаар төрийн өмчийн 705 сургуулийн 236 буюу 33,4% хоёр болон түүнээс дээш хоол үйлдвэрлэлийн байртай гэсэн үр дүн гарсан. 2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дундын гал тогоо байгуулах боломжийг тодорхойлох урьдчилсан судалгааг Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Өмнөговь, Булган 6 аймгаас авч төслийн нэгжид хүргүүлэн эхний байдлаар Дархан-Уул аймаг сонгогдсон. Дархан-Уул аймагт судалгааны ажлын хүрээнд 2 удаагийн уулзалт зохион байгуулсан. Хавсралт: 6 файл	10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	-----------------	--	--	--	---	------------------------------	--

1.2. Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хоол шим тэжээлийн боловсрол олгох, хүнсний хангамжийг сайжруулах чиглэлээр боловсролын газар, хэлтэс, анхан шатны боловсролын байгууллагыг хууль тогтоомж, бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр хангах, сургалт, сурталчилгаа, зөвлөмж чиглэл гаргаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх

6	Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийн ур чадварыг сайжруулах үе шаттай сургалтыг зохион байгуулна. Эхний хагаст: Сургууль, цэцэрлэгийн хоол зүйч, тогооч, хүнс нийлүүлэгч байгууллага, төрийн албан	Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан албан хаагчдын тоо	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах зорилгоор 2051 албан хаагчдад 11 удаагийн сургалт зохион байгуулсан.	3	1. "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулах, хоол зүйч, багш мэргэжилтнүүдийг чадавх бэхжүүлэх" ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн БГ, БХ, ЭМГ, ХХААГ-ын нийт 80 албан хаагчдад 2025 оны 01 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд "Зохистой хооллолт ба боловсрол" сургалтыг ШУТИС-ын VIII-р байрын хурлын танхимд зохион байгуулсан. 2. Дархан-Уул аймгийн сургалтын байгууллагын хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах зорилгоор аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан албан хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруулах сургалтыг ШУТИС, Хүүхдийн хоол шим тэжээл сургалт арга зүйн үндэсний төвтэй хамтран 2025 оны 01 дүгээр сарын 13-14 өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад 120 хоол зүйч, эмч, тогооч хамрагдсан. 3. Төв аймгийн цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер, хоол зүйч нарт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын баримт бичиг, хүнсний хангамжийн талаарх мэдээлэл, сургалтыг Боловсролын ерөнхий газрын СХГ-ын албан хаагчидтай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	---	--	---	---	---	---	------

	хаагчдад зориулсан сургалтыг 3 удаа зохион байгуулсан байна. Жилийн эцэст: нийт 6 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулна				хамтран 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад тус аймгийн нийт 103 ажилтан албан хаагч хамрагдсан байна. 4. "Fix my food" нөлөөллийн ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 28-30 хооронд Дорнод аймгийн 1, Хан-уул ерөнхий боловсролын сургуулийн хоол шим тэжээлийн орчныг үнэлэхэд суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх арга зүй дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төв, дэлхийн зөн ОУБ, тус аймгийн Боловсрол, Эрүүл мэндийн газар, хамтран сургалт зохион байгуулсан. Сургалтад тус аймгийн Боловсролын газрын, Эрүүл мэндийн газар, Хоол зүйч, 10, 11 дүгээр ангийн 20 суралцагч, 4 албан хаагч нийт 24 хүн хамрагдсан. Хавсралт: 13 файл		
7	Нэгж байгууллагуудад хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлэх Эхний хагаст: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 зөвлөмж	- Боловсруулсан зөвлөмжийн тоо - Гүйцэтгэлийн хувь	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 2 удаагийн зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.	1	Боловсролын ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1/662 тоот дугаартай албан бичгээр сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх хүрээнд "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл"-ийг аймаг, нийслэлийн боловсролыг газарт хүргүүлсэн. Тус чиглэлийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2025 оны 02-р сарын 25-ны өдрийн дотор манай газарт ирүүлэх чиглэл өгч тайланг хүлээн авч нэгтгэсэн. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	боловсруулан хүргүүлсэн байна. Жилийн эцэст: нийт 2 зөвлөмж хүргүүлсэн байна.						
8	Сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний чанар хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөн туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. Эхний хагаст: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж 20 байгууллагыг хамруулна. Жилийн эцэст:	- Хамрагдах байгууллагын тоо - Гүйцэтгэлийн хувь	Нийт ерөнхий боловсролын н сургууль, цэцэрлэг нийт 96 байгууллага д мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.	20	Сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний чанар хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөн туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд мэргэжилийн байгууллагуудыг оролцуулан 2 удаагийн ажлын хэсгийг байгуулан нийт 45 байгууллагад хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Үүнд: 1. Боловсролыг ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/73 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний чанар хүртээмж, аюулгүй байдлыг хангах, төрийн худалдан авах ажилланы газрын цахим дэлгүүрт байршсан аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах чиглэлээр 14, 158, 52, 31, 124, 28, 145, 27 дугаар сургууль 302, 1, 160, 38 дугаар цэцэрлэг, 16 аж ахуй нэгж байгууллага нийт 28 байгууллагаар 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 04 сарын 25-ны өдрийн хооронд яналт-шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Тус хүрээнд 14, 158, 52, 31, 124, 28, 145, сургуулиудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчны үнэлгээг Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт, үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийж ажилласан. Ерөнхий боловсролын 7-н сургууль, 4-н цэцэрлэг нийт 11 боловсролын байгууллагад үнэлгээ хийхэд 14, 31, 124, 145 дугаар сургуулиуд 65%-аас 79%-ийн хооронд үнэлэгдэж III дугаар түвшин, 158, 52, 28 дугаар сургуулиуд, 71, 38, 302, 160-дугаар цэцэрлэгүүд 65%-иас доош оноо авч IV дүгээр түвшинд тус тус үнэлэгдсэн. 2.Боловсролыг ерөнхий газрын даргын 2025 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/135 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ХҮҮ-г бусдаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	Нийт 40 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.				гүйцэтгүүлдэг сургуулийн түрээсийн гэрээг дуусгавар болгох чиглэлээр 133, 102, 33, 44, 97, 84, 12, 104, 105, 162, 55, 116, 29, 63, хөгжил, БЗЦ буюу 68-р сургууль, 10, 186 дугаар цэцэрлэгт 2025 оны 05 дугаар сарын 28 -ны өдрөөс 2025 оны 06 дүгээр сарын 06 -ны өдрийн хооронд хяналт-шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Хавсралт: 9 файл		
9	Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын байгууллагатай хамтран ажиллах Эхний хагаст: Жайка төслийн хүрээнд Дархан –Уул аймагт 1 удаа сургалт, уулзалт зохион байгуулж цэцэрлэг сургуулийн 100 хоол зүйч, тогооч нарыг сургалтад хамруулсан байна. Жилийн эцэст: КОЙКА олон улсын	- Хамтарсан байгууллагын тоо - Гүйцэтгэлийн хувь	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын 3 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.	100	1. Япон Улсын "Жайка" олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэхээр Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Өмнөговь, Булган 6 аймгаас авсан. Төслийн багтай хамтран зохион байгуулсан уулзалтын үр дүнд Дархан-Уул аймагт дундын гал тогоо байгуулах урьдчилсан судалгааг эхлүүлээд байна. Тус ажлын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 13,14-ны өдөр төсөл хэрэгжүүлэгч болон аймгийн Засаг дарга болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан уулзалт зохион байгуулсан. Мөн үеэр аймгийн сургууль цэцэрлэгийн нийт 120 хоол зүйч, эмч, тогооч нарт зориулсан сургалтыг ХХҮШТСАЗҮТ-тэй хамтран зохион байгуулж мэдлэг, ур чадварыг сайжруулсан. 2. Койка төслийн хүрээнд 2020 онд СХД-ийн 117 дугаар цэцэрлэгийг жишиг болгон тохижуулсан бөгөөд "Ерөнхий боловсролын сургуулийн орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд хэрэгжиж буй зорилтот төслийн 10 сургуулийн хоол зүйч, нийслэл болон дүүргийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдийг нэгдсэн ойлголттой болгох, хоол шим тэжээлийн боловсрол олгох ур чадварыг сайжруулах, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 28-ны төслийн нэгж, Нийслэлийн боловсролын газар, Хүүхдийн хоол үйлдвэрлэл шим тэжээл сургалт арга зүйн үндэсний төвтэй хамтран сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 23 ажилтан, албан хаагч хамрагдсан. 3. "ХХҮСАҮТ"-ийн барилгын зураг төсөл зохиогчоор "Агниста инженеринг" ХХК шалгарч хэрэгжүүлсэн, барилга угсралтын ажлыг "ЭМТИ ЭМ ЖИ" ХХК 25%-ийн гүцэтгэлтэй ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “ХХҮСАҮТ”-ийг ашиглалтад оруулсан байна.				2025 оны 08 дугаар сарын 21-ны өдөр хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. Хавсралт: 13 файл		
10	Нийслэлийн төрийн өмчийн 306 цэцэрлэгийн систем хариуцсан ажилтан албан хаагчдад систем хөгжүүлэгч ААН байгууллагатай сургалт зохион байгуулах. 73 дугаар тогтоолын 5 дугаар заалтад тусгагдсан судалгааг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдээс авч	Сургалтад хамрагдсан цэцэрлэгийн тоо Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн тоо	Нийслэлийн төрийн өмчийн 306 цэцэрлэг	306	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 73 дугаар “Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчин цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол батлагдсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/709 тоот албан бичгээр эцэг эх, асран хамгаалагчдаас авах судалгааг нэгж байгууллагуудад хүрүүлсэн. Судалгаанд нийслэлийн 306 цэцэрлэгийн 26454 эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан. Тогтоолын хэрэгжилт, судалгааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналын хамт Боловсролын ерөнхий газрын 2025 оны 05 дугаар сарын 23 -ны өдрийн 1/1918 дугаартай албан бичгээр Боловсролын яаманд хүргүүлсэн. Нийслэлийн төрийн өмчийн 306 цэцэрлэг Арта Софт Скул ХХК, Дижитал эдү менежмент ХХК, Элф верс ХХК, Их нүүдэл хоолны цахим системийг бүрэн нэвтрүүлсэн байна. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
11	Өнгөний системд суурилсан цэс	Арга хэмжээнд хамрагдсан	-	200	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд өнгөний системд суурилсан нэгдсэн цэс нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажил, арга хэмжээг	1-р сар, 2-р сар, 3-р сар,	100%

	арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ерөнхий боловсролын сургуулийн тоо			хэрэгжүүлсэн. Үүнд: 1. "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар авах арга хэмжээний чиглэл"-ийг аймаг нийслэлнийн боловсролыг газарт 2025.02.13-ны 1/662 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус зөвлөмжийн 2.1 дэх хэсэгт "Орон нутгийн онцлог улирлын шинж чанар, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын нас биеийн онцлогт тохирсон шим тэжээлийн тэнцвэртэй хоолны жишиг нэгдсэн цэс боловсруулж нэгж байгууллагыг мэргэжил арга зүй, нэгдсэн удирдлагаар хангах" чиглэлийг хүргүүлсэн. 2.Аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдэд "Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоолны цэсэд өнгөний систем нэвтрүүлэх арга зүй" сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 17, 05 дугаар сарын 01-ны өдрүүдэд 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. ШУТИС-тай хамтран зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 65 албан хаагч хамрагдсан. 3. Өнгөний системд суурилсан шим тэжээлийн тэнцвэртэй хоолны цэс төлөвлөх арга зүйн видео контентыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бэлтгэж нэгж байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан. (https://www.facebook.com/share/v/1AuX9QQBAB/?mibextid=wwXlfr) /2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 21,1 мянган үзэлттэй байна/ 4.Үйл ажиллагааны үр дүнд Баянхонгор /32/, Булган /22/, Дундговь /18/, Өвөрхангай /34/, Сүхбаатар /16/, Завхан /31/, Орхон /17/, Увс /27/, чингэлтэй дүүрэг /19/ 8 аймаг 1 дүүрэг нийт 216 сургууль нэгдсэн жишиг цэс нэвтрүүлж хоол үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулж байна. Нэгдсэн цэс хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд ХҮҮ-г нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тооцох, хоолны чанарт хяналт тавих боломж бүрдсэн. Хавсралт: 6 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---------------------------	------------------------------------	--	--	--	--	--

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Зохистой хооллолт ба эрүүл мэнд сургалтад хамрагдсан байна.	Сургалтда хамрагдаж гэрчилгээ авсан байна.	0	Сургалтад бүртгүүлэх	1. "Эрүүл монгол хүн" Үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд "Зохистой хооллолт ба боловсрол" сургалтад хамрагдсан. 2. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Койка олон улсын байгууллагын зохион байгуулсан төрийн албан хаагчдын сургалтад хамрагдсан. 3. 2025 оны 05 дугаар сарын 08 -ны өдөр БЕГ-ын 202 тоотод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн танилцуулга сургалтад хамрагдсан Хавсралт: 8 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдах	сургалтад хамрагдах	0	Сургалтын төв судлаж бүргүүлэх	2025 оны 07 дугаар сард ээлжийн амралтаар хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад бүртгүүлэх төлөвлөгөөтэй байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн, Сүхтэй Эрдэнэсайхан /...../

Огноо: